



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/146

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу иргэн Балдандорж овогтой Энхнарангийн Бэрх 7 дугаар багийн Тээвэрчин 6-р гудамж 633 тоот хаягт байрлах Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 2304012059 нэгж талбарын дугаар бүхий 700 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Балдандорж овогтой Энхтуяа шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Б.Энхтуяад үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Т.Очирбат/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны а/133 тоот захирамж болон 0000016722 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЖАВХЛАНБАЯР

230423345